

Үр дүн: Нийт 241705 өвчтний түүхэнд судалгаа хийж, Кавасакийн өвчний 9 тохиолдлыг илрүүлсэн ба КӨ-тэй хүүхдүүдийн насыг авч үзэхэд 1 нас 4 сартайгаас 14 насны хооронд хэлбэлзэж, дийлэнх нь (77,8%) нь эрэгтэй хүүхдүүд байлаа. КӨ-ний 6 (67%) тохиолдолд үндсэн 6 шинжүүд бүгд илэрсэн ба бусад тохиолдлуудад 4 ба 5 шинжүүд илэрчээ. Халуурах, нүдний салст улайх, уруул амны хөндийд өөрчлөлт гарах шинжүүд нь хамгийн элбэг тохиолдож байсан бол хүзүүний тунгалгийн булчирхай томрох шинж нь харьцангуй цөөн илэрсэн байв. Зүрхний эхокардиографийн шинжилгээ хийлгэсэн 5 хүүхдэд бүгд зүрхний талаас хүндрэл гарч, зүрхний титэм судасны өргөсөл, цүлхэн үүссэн байна.

Дүгнэлт: КӨ-ний тохиолдлыг илрүүлэх үндэсний судалгаагаар КӨ-тэй хүүхэд Монгол Улсад байдаг болох нь тогтоогдоо. Иймд цаашид КӨ-ний үндэсний судалгааг үргэлжлүүлж, тохиолдлуудыг бүртгэж мэдээлдэг, шалтгааныг нь тогтоох шаардлагатай байна.

Нийслэлийн Хан-Үул дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийг үнэлсэн судалгаа

Ж. Баярсайхан¹, Ч. Бямбасүрэн², Д.Өлзиймаа¹

¹Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв,

²Улсын Клиникийн Төв Эмнэлэг

Өсвөр үеийнхний “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн талаарх мэдлэг хандлагыг тогтоох, гэр бүл төлөвлөлт болон, бэлгий харьцаа, жирэмслэлтээс сэргийлэх аргын мэдлэг тогтоох зорилгоор олон улсын болон Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн, өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдсэн төслийн үр дүнг төсөлхэрэгжсэн болон төсөлхэрэгжээгүй газрын хүүхдүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг хандлагын түвшинг тогтоох замаар үнэлэв. Үг судалгааг системчилсэн түүврийн аргаар ХҮД-ын ерөнхий боловсролын сургуулиудын НҮЭМ-н төсөлд хамрагдсан болон төсөлд хамрагдаагүй 15, 52, 7-р сургуулийн нийт 102 хүүхдээс системчилсэн түүврийн аргаар судалгааг авч, шуглуулсан мэдээ баримтаяа Microsoft Excel, Microsoft Word программуудыг ашиглан боловсруулалт хийв.

Судалгааны ажлын таамаглал

Н0: НҮЭМ-ийн төсөлд сургалтанд хамрагдсан эсэхээс үл хамаарч судалгаанд хамрагдсан ХҮД-ийн арван нэгэн жилийн гурван сургуулийн 14-17 насны сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин ижил байна.

Н1: НҮЭМ-н төсөлд сургалтанд хамрагдсан сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин сургалтанд хамрагдаагүй хүүхдүүдээс ялгаатай байна.

Үр дүн: НҮЭМ-тэй холбоотой мэдээлэл хангалтгүй гэж төсөлд хамрагдсан сурагчдын 38.1%, төсөлд хамрагдаагүй сурагчдын 26.6% нь тус тус үзэж, тэдний 11.5% нь илүү ихээр мэдээлэл шаардлагатай байна гэж хариулжээ. Төсөлд хамрагдсан сурагчдын 56.3% нь хамрагдаагүй сурагчдын 65.9% нь хэвлэлээс мэдээллээ олж авдаг гэсэн бол НҮЭМ-ийн талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилдлаггүй гэж төсөлд хамрагдсан сурагчдын 53.7% нь төсөлд хамрагдаагүй сурагчдын 55.5% нь тус тус хариулсан нь төсөлд хамрагдсан сурагчдын 1.8% нь гэр бүлийнхэнтэйгээ бага ярилдаг ажээ. БЗХӨ-ний талаар зохих хэмжээний ойлголттой гэж төсөлд хамрагдсан сурагчдын 87.5% нь, хамрагдаагүй сурагчдын 75% нь хариулсан нь төсөлд хамрагдсан сургачдын мэдлэг хамрагдаагүй сурагчдаас 12.5%-иар илүү байгааг харуулж байна. БЗХӨ авсан байж болзошгүй гэж үзвэл хамгийн түрүүнд эмнэлэгт хандана гэж төсөлд хамрагдсан сургуулын сурагчдын 38.1% нь төсөлд хамрагдаагүй сургуулын сурагчдын 35.1% нь эмнэлэгт хандана гэж хариулсан нь төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургуулийн сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэг хандлага ялгаатай байгааг харуулж байна.

Дүгнэлт: Н1 таамаглал буюу НҮЭМ-н төсөлд сургалтанд хамрагдсан сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин сургалтанд хамрагдаагүй хүүхдүүдээс ялгаатай байна.

HBsAg илэрсэн Монгол хүүхдүүдийн цочмог А вирусийн халдварын эмнэлзүйн онцлог

Ж.Улаан¹. Я.Давгадорж², Д.Чимэдноров¹, Б.Батсүх¹

¹Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв,

²Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

Монгол улсад В вируст хепатит нь нутагшмал халдварт. Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 1991 оноос В вируст хепатитын вакцинаар шинээр төрсөн хүүхдүүдийг дархлаажуулж эхэлсний дүн А цочмог вируст хепатитын өвчлөл, элэгний дутагдлын улмаас нас барах нь эрс буурсан. Гэвч практикт цочмог А болон В вируст хепатитын хавсарсан хэлбэрийн өвчлөл бүрэн зогсоогүй байна.

Зорилго: HBsAg илэрсэн хүүхдүүдэд цочмог А вирусийн халдварын эмнэлзүйг судлах

Үр дүн: 1-р бүлгийн хүүхдүүдэд хүнда хэлбэр 7.8%, хүндэвтэр хэлбэр 23.5%, 2-р бүлэгт хүнда хэлбэр 50%,

хүндэвтэр хэлбэр 12,5%, харин 3-р бүлэгт нэн хүнд хэлбэр 25%, хүнд хэлбэр 15% байсан. Нэн хүнд хэлбэрийн тохиолдол нь зөвхөн цочмог В вирусийн халдвартай байсан. Эмнэлзүйн шинж тэмдэгийн

| | HBSAg(+), anti-HAV(+), anti-HBcIgM(-) | HBSAg(+), anti-HAV-IgM(+), anti-HBcIgM(+) | HBSAg(+), anti-HAV-IgM(-), anti-HBcIgM(+) |
|------------------------------|---------------------------------------|---|---|
| Хордлого үргэлжилсэн хугацаа | 4 өдөр | 6 өдөр | 7 өдөр |
| Шарплт үргэлжилсэн хугацаа | 7 өдөр | 11 өдөр | 12 өдөр |
| АЛАТ хэвийн болсон | 20.2 өдөр | 24.6 өдөр | 33.4 өдөр |

явшыг бүлгүүдээс нь хамааруулан хүснэгтэнд үзүүлэв

Дүгнэлт: HBSAg илэрсэн хүүхдүүдээд цочмог А вирусийн халдвартын шарлалттай хэлбэр нь цочмог А вируст хепатитын адил хөнгөн хэлбэрээр явагдаж байна.

Халдвартай хэлбэрийн сүрьеэгийн өвчлөлийн судалгаа

П. Нямшишиг, Х. Одсүрэн, Д.Долгормаа, Х.

Давааням, М. Нансалмаа

Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв

Монгол улсад жилд 10000 хүн амд тутамд 217 хүн сүрьеэ өвчнөөр шинээр өвчилж байна. Хүүхдийн сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор халдвартай хэлбэрийн сүрьеэ, олон эмийн дасалтай сүрьеэ (ОЭДС)—ийн өвчлөл нэмэгдэж байгаа нь сэтгэл эмзэглүүлсэн асуудал болж байна. Сүүлийн 3 жилд нийт 731 хүүхэд хэвтэн эмчлүүлснээс 19.2% (140) хүүхэд XTH+/+ сүрьеэгээр өвчилсөн байна.

Зорилго: Хүүхдийн сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн дундах хүчилд тэсвэртэй нян зэрэг (/XTH+/+) сүрьеэ, ОЭДС-н өвчлөл, цэрний түрхэцийн шинжилгээнд хүчилд тэсвэртэй нян зэрэгээс сөрөгт шилжих хувь, ОЭДС-р өвчилсөн хувийг тодорхойлох, өвчлөлд нөлөөлж буй зарим шалтгааныг судлах.

Материал, арга зүй: 2005-2007 онд ХӨСҮТ-ийн хүүхдийн сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн бүртгэлд эргэмж судалгааг хийв.

Үр дүн: Хүүхдийн сүрьеэгийн тасагт 2005 онд 255 хүүхэд хэвтэн эмчлүүлсний 16.5%(42), 2006 онд 218 хүүхэд хэвтэн эмчлүүлсний 19.7% (43), 2007 онд 258 хүүхэд хэвтэж эмчлүүлсний 21.3% (55) нь тус тус XTH+/+ сүрьеэгээр өвчилсөн байв. Эмчлүүлэгчдийг насын бүлгээр үзэхэд 0-5 насынхан 19.6% (143), 6-10 нас -18.3%, (136), 11-15 нас-46.6% (343), 16-18 насынхан 15.5% (114)-ийг тус тус эзэлж байна.

XTH+/+ сүрьеэгээр өвчлөгсөдийн дотор 0-5 насынхан 0%, 6-10 насынхан 7.8% (80), 11-15 насынхан 52.1%(73), 16-18 насынхан 31.4%(51) байна. XTH /+ / сүрьеэгээр өвчлөгсөдийг хүйсийн байдлаар авч үзвэл: 2005 онд эмэгтэй 24(57.2%), эрэгтэй 18 (42.8%), 2006 онд эмэгтэй 24(55.8%), эрэгтэй 19 (44.2%), 2007 онд эмэгтэй 31(56.2%), эр 24(45.6%) байна. Хүүхдийн сүрьеэгийн тасагт 2 дахь сардаа хэвтэн эмчлүүлэгсэдийн цэрний түрхэцийн 140 шинжилгээгээр XTH /+ гарсан тохиолдолийн цэрийг өсгөвөрлөхөд өгөхөд 16 (2006 онд - 4, 2007 онд 12) нь эмийн дасалтай болох нь батлагдсан. Үүнээс 12 хүүхэд ОЭДС-н эмчилгээнд хамрагдаж эдгэрч гарсан ба 4 хүүхэд нас барсан.

Дүгнэлт:

1. Уушгини хэлбэрийн түрхэц зэрэг сүрьеэгээр өвдсөн хүүхдүүдийн цэрний түрхэцийн шинжилгээнд хүчилд тэсвэртэй нян зэрэгээс сөрөгт шилжих хувь багасч байгаа нь хүүхэд хүндэрсэн үедээ оношлогдож байгаатай холбоотой байна.

2. Ушигны хэлбэрийн түрхэц зэрэг сүрьеэгээр өвдсөн хүүхдүүдийн дотор 11-18 насын эмэгтэй хүүхэд зонхилон өвчилиж байна.

3. Хүүхдүүдийн дунд ОЭДС-н өвчлөл нас баралтжил ирэх тусам нэмэгдэж байна.

Цээжний хөндийн идээт үрэвсэлийн үүсгэгч, түүний антибиотик мэдрэг чанарыг судалсан нь

О.Жавзандулам Х. Эрдэнэцээг

Э. Сүхээ, Ж. Алтанбагана

Халдварт Өвчин Судалын Үндэсний Төв

ХӨСҮТ-ийн мэс заслын тасагт 2005–2009 оны хооронд цээжний хөндийн идээт үрэвсэл оноштойгоор нийт 155 эмчлүүлэгч хэвтэж эмчлүүлснээс мэс засал эмчилгээг 102 тохиолдолд хийсэн байна. Энэ нь сүүлийн 4 жилд хийсэн мэс засал эмчилнээний 6% -г эзлэж байна. 2005-2009 оны хооронд цээжний хөндийн идээт үрэвсэлээр өвчилсөн тохиолдолуудын өвчний түүхэнд судалгаа хийж үзэхэд 155 тохиолдоос 6 (3%) нь нас барсан, 102 (65,8%) нь мэс засал эмчилгээ хийлгэсэн байна. Эдгээр мэс засал хийлгэсэн өвчтөнүүдэд хагалгааны өмнө болон дараа өргөн хүрээний антибиотикуудыг сонгон хэргэлсэн боловч цээжний хөндийн идээнд бактериологи шинжилгээ хийж эмгэг төрүүлэгч нянг илрүүлээгүй, эмгэг төрүүлэгч нянгын антибиотик мэдрэг чанарыг үзэж тохирсон антибиотикуудыг сонгон авч хэргэлсэн тохиолдол таарсангүй.

Зорилго: Цээжний хөндийн идээт үрэвсэлийг зонхилон үүсгэх эмгэгтөрөгч нян, тэдгээрийн мэдрэг